

БАТЛАВ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Ж.БАЯРМАА

2026 оны 03 дугаар сарын 20-ны өдөр

САНАЛ ХУДАЛДАН АВАЛТЫН ЭСРЭГ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт “Монголын ард түмэн бид эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” гэж тодорхойлон заасан. Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1-д “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”, 2-т “Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар завдахыг хориглоно.” гэж, Арван зургадугаар зүйлийн 9-д Монгол Улсын иргэн “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй...” гэж, Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж тус тус хуульчилсан.

Үндсэн хуульд заасан эрхэм зорилгод хүрэхийн тулд Үндсэн хуулийн биелэлт, хэрэгжилтийг хангах асуудал чухал юм. Монгол Улсын Үндсэн хуульд заасан төрийг удирдах эрхээ иргэд чөлөөтэй эдлэх, хэрэгжүүлэхэд улс төрийн эрх мэдлийг хувийн болон бүлгийн явцуу ашиг сонирхол, хүсэл зорилгодоо ашиглах, сонгогчдын саналыг худалдан авах үйлдэл нь илтэд нөлөөлөх болжээ. Сонгогчдын саналыг худалдан авах үйл явц нь эрх мэдлийг хууль бусаар олж авах зорилготой үйлдэл бөгөөд сонгуулийн болон сонгуулийн бус аль ч цаг хугацаанд явагдаж байдаг. Сонгуульд оролцогч этгээдүүд и ~~И~~ргэдийн сонгуулийн эрхээ эдлэх, засаг төрөө шударгаар байгуулах, удирдах, оролцох үйл явцад хөндлөнгөөс хууль бусаар нөлөөлж, сонгогчдын санал худалдан авах үйл ажиллагааг тасралтгүйдэл гарч—хийдэгт байгаад—олон нийт ихээхэнийн шүүмжилж~~ж~~я, эсэргүүцэ~~ж~~я иж байна.

Сонгогчдын саналыг худалдан авах үйлдэл нь хууль бус үйлдэл бөгөөд энэ нь үндэсний аюулгүй байдал, шударга ёс, эрх зүйт төрд харш үзэгдэл юм.

Улс төрийн сонгуулийн авлигажсан байдал, хууль зөрчиж сонгогчдын саналыг худалдан авах үйл явц эцэстээ чөлөөт, ардчилсан сонгуулийн ач

холбогдлыг багасгаж, улс төрийн намыг авлигад автуулж, төрийн бүтэцийг данхайлгаж, улсын төсөв, хөрөнгө оруулалт нэмэгдсэн ч иргэдэд үзүүлэх бодит үр ашиг, үйлчилгээний чанарыг суларуулжч, гажуудсан ардчилалд хүргэдэг нийтэд илэрхий үзэгдэл юм.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа - 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг”-т “Төрийн бодлого, үйл ажиллагааны тогтвортой байдалд эерэг нөлөөтэй сонгуулийн тогтолцоо бүрдэж, иргэдийн улс төрийн боловсрол дээшлэн, иргэд, сонгогчдын хариуцлага сайжирна, улс төрийн намуудыг улс орныхоо төлөө бодлогын нам болгох нийгэм, улс төрийн соёлыг төлөвшүүлнэ, ардчилсан сонгуулийн зарчмуудыг бүрэн хангасан сонгуулийн соёл хэвшсэн байна.”, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.2 дэх дэд хэсэг "Авлигагүй засаглал" хүрээнд 4.2.1.7-д "Улс төр дэх мөнгөний нөлөөллийг бууруулж, сонгогчдын саналыг худалдан авах аливаа ажиллагааг зогсооно." хэмээн тусгасан байна.

Авлигатай тэмцэх зорилгоор УИХ-ын 2023 оны 59 дүгээр тогтоолоор Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг (2023-2030 он) баталсан байна. Уг хөтөлбөрийн зорилго нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, үндэсний шударга ёсны тогтолцоог ~~бэхжүүлэх~~ батжуулах замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг ~~—бэхжүүлэх~~ сайжруулж, ~~—~~нийгмийн бүх түвшинд шударга ёсыг эрхэмлэсэн хандлагыг төлөвшүүлэн, шударга ёсны засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн байна.

Уг хөтөлбөр ~~тийн хүрээнд~~ уУлс төрийн хүрээнийд авлигатай тэмцэх хүсэл зориг, хүчин чармайлт, манлайлал, ил тод байдлыг төгөлдөршүүлэх зорилгыг тэргүүн ээлжинд дэвшүүлсэн байна. Уг зорилгын хүрээнд:

Зорилт 1.2. Сонгуулийн бус үеэр санал худалдан авахад чиглэсэн бүх хэлбэрийг хориглоно.

1.2.1.Улсын Их Хурлын гишүүн, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч бүрэн эрхийнхээ хугацаанд иргэдэд мөнгө, эдийн болон эдийн бус хөрөнгө, тэдгээрийг өмчлөх эрхийг шилжүүлэх, үнэ төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлэх, эдгээрийг амлах, санал болгох зэрэг бүх төрлийн санал худалдан авах үйлдэл гаргахыг хориглох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ.

1.2.2.Төрийн улс төрийн албан тушаалтан иргэдийн саналыг авах зорилгоор сонгуулийн бус үед төрийн ажил, үйлчилгээг өөрийн нэрээр хэрэгжүүлэх, төрийн байгууллага, албан тушаалтныг хувийн ашиг сонирхлын үүднээс үйл ажиллагаандаа татан оролцуулах, мөнгө, эд зүйл тараахыг хориглоно.

1.2.3.Сонгогчийн саналыг худалдан авахыг завдсан, худалдан авсан, сонгуулийн зардлын тайлангаа үнэн зөв гаргаагүй хүн, хуулийн этгээдэд эрүүгийн

хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг бий болгож, хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ.

Зорилт 1.1. Сонгуулийн үеэр санал худалдан авахад чиглэсэн бүх хэлбэрийг хориглож, хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

1.1.1. Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд сонгуулийн үеэр санал худалдан авахтай холбоотой гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх харьяалал, журмыг боловсронгуй болгоно гэж заажээ.

Авлига улс төрийн хүрээнд үүрлэх нь улсын хөгжлийн бодлогыг алдагдуулж, түүнээс үүдсэн бусад олон талын таагүй үр дагаварыг үүсгэдэг. Ардчилсан нийгэм бол олонхийн засаглал бөгөөд түүнийг орлосон төлөөллийн байгууллагын албан тушаалтнууд сонгогдсон бүрэн эрхийнхээ хугацаанд сонгогчдынхоо бус, зөвхөн өөрсдийн ашиг сонирхлыг хичээн, хувийн хонжоо харж ажиллах тохиолдолд улс орны хөгжлийн тууштай бодлого, хэрэгжилтийг тэднээс хүлээх нь гэнэн хэрэг болно. Улс төрийн авлига нь сонгуульд хууль бус, бохир аргаар оролцох, улс төрийн хүчин, улс төрчид бизнесийн бүлэглэлтэй хуйвалдан тэдний эрх ашигт автах, гэмт хэргийн бүлэглэлүүдтэй ил, далд холбоо тогтоох, төрийн албаны томилгооны бодлого алдагдах, үйл ажиллагааныхаа талаарх мэдээллийг аль болох нуун хаацайлах зэрэг олон хэлбэрээр илэрнэ. Бизнесийн бүлэглэл, зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд өөрсдийнхөө үйл ажиллагааны аюулгүй байдал, ашиг орлого, хүч нөлөөг өсгөх хамгийн үр нөлөөтэй арга нь улс төрийн намуудыг, сонгуульд нэр дэвшигчдийг санхүүжүүлэх явдал байдаг. Сонгуулийн үед сонгогчдын хувьд материаллаг сонирхол төрүүлж санал худалдаж авах нь улс төрийн авлигын бас нэг гол хэлбэр юм. Ийм байдлаар сонгуульд оролцсон улс төрийн хүчнээс шударга ажиллагаа хүлээх нь утгагүй болно. Улс төрд авлига ихээхэн нүүрлэх нь нийгмээрээ нэг хөлөг онгоцон дээр их далайд яваатай зүйрлэвнэл, онгоц залуургүй болсонтой ижил нөхцөл байдлыг бий болгоно.¹

Улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий тольд: авлига, клиентализм болон улс төрийн бусад эмгэг нутагшсан төр эцэстээ нурж унах магадлалтай, олон нийтийн өмнө хариуцлага үүрэхдээ дүр үзүүлдэг, үнэн хэрэгтээ авлигчид автсан албан тушаалтны хяналтад байдаг улс төрийн тогтолцооны гол бэрхшээл нь албан тушаалтны хээл хахуульд автамтгай байдал² болохыг тодорхой дурджээ.

Дээд түвшний авлига Монголд оршиж байгаа гол шалтгаан нь улс төр, бизнесийний бөлон улс төрчдийн нийлсэн эрх ашиггийн төлөөх сонирхлын нэгдэл бөлон хувирч буйн илрэл гэж үзэж бөлонэзааг, ялгаа арилж, эрх мэдэл, хөрөнгө мөнгөний төлөөх харилцан хамаарал бүхий “сүлжээ” үүссэнтэй холбоотой. Цаашлаад улс төрийн намын санхүүжилтийн нээлттэй бус, тодорхойгүй механизм нь улс төрийн авлигад хүчтэй нөлөөлж, улмаар үүнээс үүдэлтэй улс төрийн тогтворгүй байдал үүсэх явдал сүүлийн жилүүдэд илт

¹ Д.Зүмбэрэллхам, Авлигын гэмт явдал, УБ., 2007 он, 8-9 дэх тал

² Боловсрол, Шинжлэх ухааны яам, Монгол Улсын Их сургууль, Улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий толь бичиг, УБ., 2020 он, 34, 35 дахь тал,

мэдрэгдэх болсон нь худал ~~биш~~ зүйл биш юм. Сүүлийн нэг жилийн хугацаан (2020)-д улс төрийн хүрээнд авлигын хэлбэрүүд хэрхэн тархсаныг тооцохул, бизнест үнэ төлбөргүй хөрөнгө оруулах, сонгуулийн үеэр сонгогчдын саналыг худалдан авах, ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, гаргуулах, аж ахуйн нэгжид давуу байдал бий болгох, төсвийг хувийн ашиг сонирхлын дагуу хуваарилах, хээл хахууль авах, өгөх, зуучлах, шан харамж авах, өгөх, мөнгө угаах зэрэг үйлдлүүд нь авлигыг өөгшүүлэх байдлыг улам нэмэгдсэнийг шинжээчид онцолсон.³

Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлд **“Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар завдахыг хориглоно.”** гэж заасан бөгөөд манай улс нь төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, ашиглах үйлдэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй бүх түвшинд тэмцэх явдал чухал байна.

Манай улс Транспэрэнси Интернэшнл (ТИ) байгууллагаас гаргадаг Авлигын төсөөллийн индекс (АТИ)-ийн 2025 оны үзүүлэлтээр 182 улс орноос 31 оноо авч 124 дүгээр ~~т~~-эрэмблэгдсэн.⁴ 2023 оны дүнгээр 33 оноо авч, 180 улс орноос 121 дүгээр байрт эрэмбэлэгдсэн. Сүүлийн 12 жилийн хугацаанд АТИ-ийн дэлхийн дундаж оноо өөрчлөгдөөгүй буюу 43 гараад байна (боломжит 100 онооноос). Дэлхийн улс орнуудын гуравны хоёр нь 50-аас доош оноо авсан нь эдгээр улс орнуудад авлига ноцтой асуудал болсныг илтгэж байна.⁵ 2024 онд 33 оноогоор Непал, Нигер зэрэг улсын дараа 114 дүгээр байрт Беларус, Ангола зэрэг улстай зэрэгцэн эрэмбэлэгдсэн байна.⁶

АТГ-т 2018 онд 1887 өргөдөл, гомдол хүлээн авч байсан бол 2022 онд 2785, 2023 онд 3749, 2024 онд 2946 гомдол, өргөдөл хүлээн авч⁷ шалгасан байна.

Монгол Улс дахь авлигын асуудал нь сонгогчдын санал худалдан авалтын суурь шалтгаан нөхцөл мөн гэж дүгнэж болно. Харин авлингатай тэмцэх иргэдийн хүсэл санаачилга улам бүр өсөн нэмэгдэж байгаа нь өндөр ач холбогдолтой юм. Улс төрийн сонгуулийн мөнгөний нөлөөг багасгах, санал худалдан авалтыг хязгаарлах, хориглох чиглэлээр хууль тогтоомжийн шинэчлэлийг тухай бүр хийж ирсэн байдаг. Өнөөдөр манай улсад авлига, албан тушаалын гэмт хэрэг, сонгогчдын санал худалдан авалтын эсрэг зохицуулалтыг УИХ-ын сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөө урьдчилан сэргийлэх тухай хууль, Монгол Улсын Эрүүгийн болон Зөрчлийн тухай хууль тогтоомжоор зохицуулсан байдаг ч бодит нөхцөл шалтгааныг харгалзан хууль тогтоомжийг боловсронгуй болгох, чангатгах, нарийвчлан зохицуулах зайлшгүй шаардлагатай байна.

³ О.Хатанболд, Ц.Бадам, Улс төрийн хүрээн дэх авлигын цар хүрээ ба хэлбэр: шинжээчдийн судалгаанд хийсэн шинжилгээ, АТГ, Шударга ёс, 2023/1, №25, 78, 91 дэх тал

⁴ <https://www.transparency.mn/>

⁵ АТГ, Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал, УБ., 2023 он, 59 дэх тал

⁶ <https://ubn.mn/p/77713>

⁷ ҮСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2025 III, 81 дэх тал

Сонгогчдын санал худалдан авах асуудлын мөн чанар нь удирдах эрхийг ямар ч хамаагүй аргаар авах хүсэл, үйл ажиллагаанаас үүдэлтэй бөгөөд эцэстээ төр улсыг клиентелист байдлаар ашиглах, төсөв хөрөнгийг нийтийн төлөө бус зарцуулах зэрэг хүсэл сонирхлоо хангахад чиглэгдэж байдаг. Үр дүнд нь авлига төрийн албаны бүх салаа мөчирт өргөн тархаж, захиргааны авлига үүсч, төрийн үр ашгийг багасгаж байдаг гэдэгт салбарын олон судлаачид санал нэгдсэн байна.

Улс төрийн зарим нам, эвсэл, нэр дэвшигчид эрх мэдлийг олж авах, хадгалахын тулд улс төрийн хариуцлагагүй, хууль бус, буруу арга хэлбэрийг ил, далд байдлаар ашиглах, дэмжих явдал ажиглагдаж байна. Улс төрийн голлох намуудын үйл ажиллагаа, нэр дэвшилт, томилгоо авлигажсан байгаа нь сонгогчдийн саналыг худалдаж авах үйл ажиллагааг далдуур дэмжиж байгаа хэрэг бөгөөд улс төрийн болон сонгуулийн соёл, хандлага, тогтолцооны сул талууд нь санал худалдан авалтад шууд нөлөөлж байна гэж үзэж болно.

Улс төрийн намаас төрийн сонгуульд нэр дэвшигчээ тодруулах, дотоод сонгуулийн явцад намын гишүүдээ мөнгө, эд хөрөнгөөр татах, амлалт өгөх зэрэг санал худалдан авалтыг дэмжсэн үйл ажиллагаа явагдаж байдаг. Энэ мэт улс төрийн намын буруу хандлага, соёл нь эцэстээ сонгогчдын санал худалдан авалт руу нэр дэвшигч нараа түлхэж буй хэрэг юм.

Манай улсад сонгуулийн сурталчилгааны явцад болон сонгуулийн жил эхэлсэн цаг хугацаанд л санал худалдан авалтын асуудалд анхаарал хандуулдаг. Гэтэл сонгогчдын саналыг худалдан авах үйл ажиллагаа нь ээлжит сонгуулийн жил эхлэхээс өмнөх жилүүдэд зохион байгуулалттай хийгдэж байгаа нь анхаарал татаж байна.

Сонгуулийн тухай хууль тогтоомжоор сонгогчдын саналыг татах зорилгоор хийж буй үйл ажиллагааг сонгуулийн жилд хориглосон байдаг боловч эдгээр үйл ажиллагаа сонгуулийн бус жилд маш ихээр зохион байгуулагдаж байдаг. Төрийн зарим албан тушаалтан нь сонгуулийн бус үед сонгогчдын санал худалдан авах зорилгоор төрийн нөөц, хөрөнгийг зүй бусаар ашиглах явдал гардаг. Төрийн зарим өндөр албан тушаалтан төсвийн хөрөнгөөр хийж байгаа хөрөнгө оруулалт болон худалдан авсан тоног төхөөрөмжийг сонгогчдын санал худалдан авах зорилгод ашиглах явдал байсаар байгаа нь санал худалдан авалтын нэг хэлбэр юм. Сонгуулийн бус жилд явагдаж байгаа сонгогчдын санал худалдан авах үйлдэл нь эрх зүйн зохицуулалтгүй, хийдэлтэй байгаа нь нэгэнт тодорхой байна.

УИХ-ын 2024 оны үеэр сонгуулийн хууль зөрчсөн, санал худалдан авалттай холбоотой өргөдөл, гомдол ихээхэн гарсан байдаг ч, түүний үр дүн буюу шийдвэрлэлт хангалттай байж чадахгүй байна.

Цагдаагийн байгууллагад сонгуулийн жил эхэлснээс хойш Нийслэлд 756, орон нутагт 504, нийт 1260 гомдол, мэдээлэл бүртгэгдэн харьяаллын дагуу холбогдох нэгжүүд шалгалтын ажиллагаа явуулжээ. Үүнээс гэмт хэргийн шинжтэй 473 гомдол, мэдээлэл хүлээн авснаас 292 буюу 61.7 хувийг хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзаж, 14 буюу 2.95 хувийг хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн байна. 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 167 буюу 35.5

хувь нь ажиллагаанд байгаа аж. Зөрчлийн шинжтэй 787 гомдол, мэдээлэл бүртгэгдсэнээс хүлээн авахаас татгалзсан 615 буюу 78.1 хувь, хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн 47 буюу 5.9 хувь, зөрчлийн хэрэг нээсэн 45 буюу 5.7 хувь, одоо ажиллагаанд 75 буюу 9.5 хувийг шалгаж байгааг мэдээлсэн.⁸

Энэ дүнгээс авч үзвэл, нийт 1260 гомдол, мэдээлэл ирсэнээс гэмт хэргийн шинжтэй гомдлын 61.7 хувь, зөрчлийн шинжтэй гомдлын 78.1 хувийг хэрэг бүртгэлийн хэрэг нээх, хүлээн авахаас татгалзсан байдаг нь харьцангуй өндөр үзүүлэлт юм.

Санал худалдан авалт, сонгуультай холбоотой зөрчил, хэргийг шалгах, хуулийг хэрэгжүүлэх механизм сул, шийтгэл хөнгөн, эдгээр зөрчлийг шалгаж шийдвэрлэх, илрүүлэх систем үр дүнтэй биш, хууль хяналтын байгууллага нь сонгуулийн зөрчил, санал худалдан авалттай тэмцэх хүчин чармайлт сул, өргөдөл, гомдлыг гүйцэт шалгахгүй, өргөдөл, гомдлыг хаах, хэрэгсэхгүй болгох хандлага, сонирхол нь илүү байгаа нь санал худалдан авах үйл явцыг “далд” өдөөгч, дэмжигч хүчин зүйл болж байна.

Хуулийн хийдэл, зохицуулалтгүй байдлыг ашиглаж санал худалдан авалт хийх боломжтой байгаа бөгөөд манай улсад сонгуулийн болон сонгуулийн бус үед ийм төрлийн зөрчил, сонгогчдын саналыг худалдан авсан, авах гэж оролдсон гэх мэдээлэл, өргөдөл, гомдол байнга гарч ирдэг боловч шийдвэрлэлт, эрх зүйн орчин дутагдалтай байна.

Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлд заасан Сонгуулийн хуулийг зөрчих⁹ зөрчлийн тухайд 2020-2024 онд зөрчлийн хэрэг бүртгэлт явуулсан хэргийн тоо 1119 байх бөгөөд үүнээс хэрэгсэхгүй болгосон нь 795, шийтгэл оногдуулсан нь 281 байгаа нь¹⁰ дээр дурдсан дүгнэлт үндэслэлтэй болохыг нотлож байгаа болно.

Харин Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 2022 онд Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлд заасан Сонгуулийн хуулийг зөрчих зөрчлөөр 5 хэрэг шийдвэрлэгдэж, 11 хүн шийтгүүлсэн байна, харин 2020, 2024 онд уг зүйл ангиар ямар ч хэрэг шүүхээр шийдвэрлэгдээгүй байна.¹¹

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.5 дугаар зүйлд иргэний сонгох, сонгогдох эрхийг хамгаалж, сонгогчийн санал худалдан авалтыг гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тусгасан байдаг.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.5 дугаар зүйлд заасан гэмт хэргээр 2020-2024 онд нийт 82 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, үүнээс 3 хэргийг шүүхэд шилжүүлсэн байна.¹² Тэгвэл Эрүүгийн хэргийн

⁸ Сонгуулийн ерөнхий хороо, Монгол Улсын Их хурлын сонгууль, 2024 он, УБ., 2014 он, 44 дэх тал

⁹ <https://legalinfo.mn/mn/detail/12695>

¹⁰ УЕПГ-ын 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 1/1492 тоот ирүүлсэн судалгааны дүн

¹¹ Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025.4.2-ны өдрийн 03/537 тоот албан бичгээр ирүүлсэн тоон мэдээлэл

¹² Улсын Ерөнхий прокурорын 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 1/1492 тоот албан бичгээр ирүүлсэн судалгааны тоон мэдээ

анхан шатны шүүхээр уг 14.5 дугаар зүйлд заасан гэмт хэргээр 2020-2024 онд ямар нэгэн эрүүгийн хэрэг шийдвэрлэгдээгүй байна.¹³

Гэмт хэргийн талаар гомдол, мэдээлэл цагдаагийн байгууллагад ирж, уг өргөдөл, гомдлын дагуу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явагдаж эхэлдэг боловч, эцэстээ шүүхээр орж шийдвэрлэгдсэн хэрэг байхгүй байгаа нь анхаарал татаж байна.

Дүгнэлт хийж үзвэл, санал худалдан авалтыг хязгаарласан, хориглосон хууль тогтоомжийн уялдаа холбоо, системчлэл сул, хийдэл ихтэй, зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэх, хэрэгжилт сул, хууль нь зөрчлийн үр дагаварыг зохицуулж чадахгүй бодит нөхцөл байдалтай тулгарчээ, энэ нэг талаас сонгогчдын санал худалдан авалттай тэмцэх хууль тогтоомж нь цаг үетэйгээ нийцэхгүй, хоцорсон, эрх зүйн хийдэлтэй байна гэдгийг харуулж байгаа хэрэг юм.

Иймд дээр дурдсан үндэслэл, шаардлагаар Санал худалдан авалтын эсрэг хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлсон болно.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийн зорилго нь Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт заасан сонгогчдын сонгогчдын саналыг худалдан авах бүх хэлбэрийг хориглох, санал худалдан авалтаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, олон нийтийн оролцоо, хяналтыг дэмжих, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулна.

Хуулийн төсөлд “санал худалдан авалт” гэсэн нэр томъёог тайлбарлах бөгөөд уг ойлголтод сонгуульд санал өгөх иргэний сонгох эрхэд хууль бусаар нөлөөлөх зорилгоор, эсхүл сонгуульд санал өгсний төлөө төлбөргүй, хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлэх, эд зүйл, эрх, мөнгө, бүх төрлийн урамшуулал өгөх, амлах, урлаг, соёлын тэмцээн, уралдаан ивээн тэтгэх, зохион байгуулах, шагнах, төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төсөв, өмч, хөрөнгө, албаны эрх мэдлийг ашиглах зэрэг хориглосон үйлдэл, үйл ажиллагаагаар илрэх эрх зүйн зөрчлийг хамруулахаар тусгана.

Улс төрийн намаас төрийн сонгуульд нэр дэвшигчээ тодруулах, дотоод сонгуулийн явцад намын гишүүдээ мөнгө, эд хөрөнгөөр татах, амлалт өгөх, нэр дэвшигч нараа мөнгөөр өрсөлдүүлэх зэргээр санал авалтыг дэмжсэн үйл ажиллагаа явуулж, эцэстээ нэр дэвшигч нараа сонгогчдын санал худалдан авалт руу түлхэж буй буруу хандлагыг таслан зогсоох, хариуцлага тооцох эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.

Мөн иргэн, хуулийн этгээд нь уг хуулийг зөрчиж санал худалдан авах саналыг хүлээн авсан, оролцсон, дэмжсэн, зохион байгуулсан бол хуульд заасан хариуцлага хүлээх үндэслэл болохоор тусгана. Мөн улс төрийн сонгуульд

¹³ Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2025 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 03/537 тоот албан бичгээр ирүүлсэн тоон мэдээлэл

оролцож сонгогдсон этгээд энэ хуулиар хориглосон санал худалдан авалт зохион байгуулсан, оролцсон, гуравдагч этгээдээр гүйцэтгүүлсэн гэм буруу нь шүүхээр тогтоогдсон бол түүнийг эгүүлэн татах хууль зүйн үндэслэл болох талаар тусгана.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.2 дахь хэсэгт заасан **"хувийн ашиг сонирхол** гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг" гэсэн ойлголтод **"санал худалдан авах ашиг сонирхлыг"** гэж нэмж, мөн хуулийн 3.1.11 дэх хэсэгт заасан **"ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал** гэж тухайн нийтийн албан тушаалтан өөрийн нэг ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүн гэх зэрэг олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгохуйц этгээдтэй холбоотой асуудлаар үйл ажиллагаа явуулахыг" гэсэн гэдэгт **"санал худалдан авах зорилгоор үйл ажиллагаа явуулахыг"** гэж нэмж, уг хуулийн үйлчлэх хүрээнд санал худалдан авах үйлдэл, үйл ажиллагааг хамруулахаар төсөлд тусгана. Ингэснээр санал худалдан авах үйлдэл, үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ үр дүнтэй болно гэж үзэв.

Санал худалдан авалтын эсрэг хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчийн хурлын сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

Энэ хуулийн төсөлтэй хамт хууль хоорондын уялдаа холбоог хангах үүднээс Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчийн хурлын сонгуулийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулна.

Санал худалдан авах зорилготой үйлдэл, үйл ажиллагааг хориглосон, хязгаарласан эрх зүйн зохицуулалтын агуулга, хүрээг нарийвчлан тодорхойлж, хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хуулийн хариуцлагыг чангатгах, сонгуулийн зөрчил, сонгогчдын санал худалдан авалтыг хязгаарласан, хориглосон, зөрчил, маргааныг шийдвэрлэх материаллаг болон процессын хууль тогтоомжийн уялдаа холбоо, системчлэлийг шинэчлэх, сайжруулах, хууль тогтоомжийн зөрчил, давхардал, хийдлийг арилгана. Санал худалдан авалтын эсрэг хууль тогтоомжийг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг шалган шийдвэрлэх байгууллага, албан тушаалтан хараат бус, бие даасан байдлаар ажиллах

баталгааг бүрдүүлж, хуульд заасан үүргээ биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх тогтолцоог бүрдүүлнэ.

Манай улс санал худалдан авалтыг зөвхөн сонгуулийн жилд, сонгуулийн үеэр эрх зүйн зөрчилд тооцож, хариуцлага хүлээлгэх асуудлыг зохицуулж ирсэн бол энэ төсөлд уг байдлыг халж, аливаа этгээд санал худалдан авах зөрчил гаргасан бол сонгуулийн жил эсэхээс үл хамаарна зөрчилд тооцохоор тусгана.

Хуулийн төсөл нь таван бүлэг, 16 зүйлтэй байх бөгөөд нэгдүгээр бүлэгт нийтлэг үндэслэл, хоёрдугаар бүлэгт санал худалдан авалтыг хориглох,, гуравдугаар бүлэгт санал худалдан авалтын талаар төрийн байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг, дөрөвдүгээр бүлэгт олон нийтийн хяналт, оролцоо, тавдугаар бүлэгт бусад зүйлийг тусгана.

Хуулийн төсөлд тухайн харилцаанд хамааралтай санал худалдан авалт, санал худалдан авах зорилготой гуравдагч этгээд гэсэн ойлголт болон хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтаныг тодорхойлно, мөн санал худалдан авалтын эсрэг баримтлах зарчим, хуулийн үйлчлэх хүрээг тодорхой болгоно. Хуулийн төсөлд санал худалдан авах үйлдэл хийсэн этгээд хариуцлага хүлээхгүй үлдэхгүй бөгөөд хууль зүйн хариуцлага гарцаагүй хүлээлгэх, хуулиар хориглосон санал худалдан авалтад оролцсон, зохион байгуулсан, гуравдагч этгээдээр гүйцэтгүүлсэн, дэмжсэн этгээд улс төрийн сонгуульд оролцож сонгогдсон бол эргүүлэн татах талаар үндэслэл, зарчмыг тодорхойлно.

Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт Санал худалдан авалтыг хориглох талаар, гуравдугаар бүлэгт УИХ, Засгийн газар, яам, агентлаг, бүх шатны Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, төрийн байгууллага, төрийн өмч, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, албан тушаалтны хүлээх үүрэг, мөн улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөн, намын гишүүн, иргэний хүлээх үүргийг зааж, санал худалдан авахтай холбоотой хориглох зүйлийг зааж өгнө.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт заасан ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал худалдан авах, татах зорилгоор хийхийг хориглосон үйлдэл, үйл ажиллагаатай холбоотой холбогдох заалтыг хүчингүй болгож, Санал худалдан авалтын эсрэг хуулийн төсөлд тусгана.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хувийн ашиг сонирхол гэсэн ойлголтод санал худалдан авах ашиг сонирхлыг хамруулна, мөн хуульд заасан ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал гэсэн ойлголтод санал худалдан авах зорилгоор үйл ажиллагаа явуулахыг хамруулж, Санал худалдан авалтын эсрэг хуулийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуультай уялдуулж өгнө.

Хуулийн төсөлд иргэн, хуулийн этгээд нь санал худалдан авалтын эсрэг хууль тогтоомжийг зөрчсөн асуудлаар гомдол гаргах, мэдээлэл хийх, мэдэгдэл,

байр сууриа илэрхийлэх эрхийг тусгайлан баталгаажуулж, гомдол, мэдээлэл гаргасан мэдээлэгчийг шаардлагатай тохиолдолд хамгаалах арга хэмжээг Авлигатай тэмцэх газар авах, гомдол, мэдээлэл гаргасан иргэний мэдээлэл нь үнэн бодитой нь тогтоогдсон тохиолдолд мөнгөн урамшуулал олгох, Авлигатай тэмцэх газар нь хуулийн дагуу гаргасан гомдол, мэдээллийг хүлээн авч хууль тогтоомжийн хүрээнд шалгах ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.

Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт санал худалдан авалттай тэмцэхэд олон нийтийн хяналтын оролцоо, тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны дэргэд олон нийтийн зөвлөлийг 25 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулахаар тусгана. Мөн санал худалдан авах бүх хэлбэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар төрөөс баримтлах бодлого, зорилтыг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгана.

Сонгуулийн ерөнхий газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөл нь санал худалдан авалттай тэмцэхэд олон нийтийг төлөөлөх бөгөөд олон нийтийн санал бодлыг сонсох, хуулийн хэрэгжилтийн талаар зөвлөмж гаргах, хууль тогтоомжийг сурталчлах зэрэг чиглэлээр ажиллана.

Хуулийн төсөл санал худалдан авалтын эсрэг иргэний хүлээх үүргийг заана.

Хуулийн төслийн тавдугаар бүлэгт хуулийн хариуцлага хүлээх үндэслэл, төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, тэдгээрийн албан тушаалтан, улс төрийн нам, эвсэл, түүний сонгуульт гишүүн нь санал худалдан авалт зохион байгуулсан, оролцсон, гуравдагч этгээдээр гүйцэтгүүлсэн, дэмжсэн бол хуульд заасан хариуцлага хүлээх үндэслэл болох талаар тусгана.

Мөн уг хуулийг зөрчсөн үйлдэлд Эрүүгийн хуульд зааснаар хариуцлага хүлээлгэх, хэрэг шалгах харьяалал зэргийг Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд боловсруулна.

Гурав.Хууль тогтоомж батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Энэ хуулийн төсөл батлагдсан тохиолдолд санал худалдан авалтыг таслан зогсоох, түүнтэй тэмцэх олон нийтийн хяналт, итгэл хүчтэй болж, сонгуулийн ил тод, шударга байдал хангагдаж, улс төрийн нам, улстөрчдийн хариуцлага нэмэгдэнэ.

Хуулийн төсөл батлагдсан тохиолдолд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, төрийн үйлчилгээ иргэдэд хүрэх, нийтийн албан тушаалтан олон нийтийн өмнө хариуцлагатай байх, улс төрийн зорилгоор төсвийн хөрөнгө зарцуулах, төрийн нөөц, хөрөнгийг улс төрийн зорилгоор ашиглах явдал багасах болно. Мөн ард иргэдийн төрд итгэх итгэл нэмэгдэж, улс төрийн сонгуульд итгэх итгэл нэмэгдэх, төрийн сонгууль шударгаар явагдах нөхцөл, баталгаа бүрдэнэ.

Дөрөв.Хууль тогтоомжийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсон тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал:

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа болно. Уг хуулийн төсөл нь Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай зэрэг хуультай уялдаа холбоотой бөгөөд зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, зарим зүйл, заалтыг хүчингүй болгох, мөн Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах саналтай.